



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/82.

Мандалговь

┌ “Дөл БГМ” ХХК-тай гэрээ байгуулах тухай ┐


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/46 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Дотуур байрны дээврийн засвар (Дундговь, Дэлгэрцогт сум) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Дөл БГМ” ХХК-тай 24,100,000 (хорин дөрвөн сая нэг зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу Дотуур байрны дээврийн засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Дөл БГМ” ХХК-ны гүйцэтгэх захирал (Б.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Дэлгэрцогт сумын Засаг дарга (П.Цолмонбаатар), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060322